



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

Шинэ коронавируст халдвар(COVID-2019)-ын үед болон хавдрын тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай зарим нэрийн эмэнд импортын лиценз олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь заалт, “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх хугацааг сунгах тухай” Засгийн газрын 2020 оны 102 дугаар тогтоолын 1 дэх заалт, Хүний эмийн зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Халдварт өвчин судлалын үндэсний төвд импортын лиценз олгох эмийг нэгдүгээр, Монос фарм трейд ХХК-д импортын лиценз олгох эмийг хоёрдугаар, Торгон туул ХХК-д импортын лиценз олгох эмийг гуравдугаар, Мөнхийн тун ХХК-д импортын лиценз олгох эмийг дөрөвдүгээр, Эм Эн Жи Би ХХК-д импортын лиценз олгох эмийг тавдугаар, Цомбо ХХК-д импортын лиценз олгох эмийг зургадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Бодлогоор бүртгэх эмийн бүртгэлийн үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д даалгасугай.

3. Импортлосон эмийн чанар, аюулгүй байдлыг бүрэн хариуцаж, импортлох үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж ажиллах, эмийн сан, эрүүл мэндийн байгууллагыг эмээр тасралтгүй, жигд хангаж, зохиомол хомсдол, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй байхыг эм ханган нийлүүлэх байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эм, үйлдвэрлэл, технологийн газар /Н.Гэрэлт-Од/-т даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ



2020-A-tushaal

111000718

Эрүүл мэндийн сайдын 2020 оны . 04
дугаар сарын 01.-ны өдрийн 11/217
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВД
ИМПОРТЫН ЛИЦЕНЗ ОЛГОХ ЭМИЙН ЖАГСААЛТ

Д.Д	Эмийн нэр	Тун хэмжээ	Эмийн хэлбэр	Тоо Хэмжээ	Үйлдвэрлэгчийн нэр
1	Авиган /Фавипиравир/	200мг №100	шахмал	250	"Fujifilm Toyama Chemical"


Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 дугаар сарын 01-ны өдрийн А/УТ дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



МОНОС ФАРМ ТРЕЙД ХХК-Д
ИМПОРТЫН ЛИЦЕНЗ ОЛГОХ ЭМИЙН ЖАГСААЛТ

Д.Д	Эмийн нэр	Тун хэмжээ	Эмийн хэлбэр	Тоо Хэмжээ	Үйлдвэрлэгчийн нэр
1	Арбидол /Умифеновир/	100мг №10	капсул	43,000 хайрцаг	Фармстандарт лекарства, ОХУ
2	Калидавир /Лопинавир+ Ритонавир/	200мг+ 50мг	шахмал	1,000 хайрцаг	АО "Фармсинтез" ОХУ
3	Рибавирин	200мг №30	капсул	500 хайрцаг	Озон, ОХУ
4	Номидес /Осельтамивир/	75мг №10	капсул	2,000 хайрцаг	АО "Фармасинтез", ОХУ
5	Номидес /Осельтамивир/	45мг №10	капсул	1,000 хайрцаг	АО "Фармасинтез", ОХУ

Эрүүл мэндийн сайдын 2020 оны .04
дугаар сарын .01-ны өдрийн . А/202
дугаар тушаалын гуравдугаар хавсралт



ТОРГОН ТУУЛ ХХК-Д
ИМПОРТЫН ЛИЦЕНЗ ОЛГОХ ЭМИЙН ЖАГСААЛТ

Д.Д	Эмийн нэр	Тун хэмжээ	Эмийн хэлбэр	Тоо хэмжээ	Үйлдвэрлэгчийн Нэр
1	Рибавирин	200мг №140	шахмал	2,000 хайрцаг	Faromed Lifesciences, БНЭУ
2	Хлорохин фосфат	500мг №100	шахмал	2,000 хайрцаг	Faromed Lifesciences, БНЭУ
3	Лопинавир+ Ритонавир	200мг+ 50мг №60	шахмал	2,000 хайрцаг	Auronbindo Pharma Ltd, БНЭУ

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн 4/217 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



МӨНХИЙН ТУН ХХК-Д
ИМПОРТЫН ЛИЦЕНЗ ОЛГОХ ЭМИЙН ЖАГСААЛТ

Д/Д	Эмийн нэр	Тун хэмжээ	Эмийн хэлбэр	Тоо Хэмжээ	Үйлдвэрлэгчийн нэр
1	Арбидол /Умифеновир/	100мг №10	капсул	10,000 хайрцаг	Фармстандарт-Лексредства, ОХУ